

I-V ангийн унших чадварын агуулгын залгамж холбоо

Анги	1-р анги	2-р анги	3-р анги	4-р анги	5-р анги
УНШИХ ЧАДВАР					
Унших чадварт тавигдах шаардлага уншлагын чанар	Зөв унших	Унших хурдаа нэмж, бусдад ойлгогдохоор зөв, унших	Өгсөн эхийг бусдын дэмжлэгтэй, ойлгож унших	Ойлгон уншиж, уншсанаа бусадтай хуваалцан ярилцах	Ойлгон уншиж, уншсанаа бусадтай хуваалцан ярилцах
Эхийн агуулгыг ойлгосноо харуулах	1.1.а. Өгүүлбэр, эхээс танил биш үгийг олж, утгыг нь таамаглах	2.1.а. Танил биш үгийг сурах бичгийн тайлбараас цагаан толгойн үсгийн дарааллаар үгээ сонгох, утгыг мэдэх	3.1а. Уншсан эх дэх танил биш үгийг тайлбар толь бичгээс үсгийн дарааллаар олж, агуулгыг ойлгох	4.1а. Уншсан эх дэх танил биш үгийг тайлбар толь бичгээс олж, агуулгыг ойлгох	5.1а. Эхэд ашигласан зарим үг, хэллэгийг сонгож, эхэд хэрэглэснийг утгыг тайлбарлан дүгнэх
	1.1.б. Сурах бичгийн эх, зурагт эх, богино хэмжээтэй хялбар эхийг уншиж, агуулгыг ерөнхийд нь ойлгосноо харуулах	2.1б. Уншсан шүлэг, өгүүллэг, үлгэр, зүйр цэцэн үг зэрэг эхийг уншиж, агуулгыг ерөнхийд нь ойлгосноо харуулах	3.1б. Уншсан эх, үлгэр, өгүүллэг, шүлгээс чухал хэсгийг ялгаж, ойлгосноо харуулах	4.1б Уншсан эхийн болон үлгэр, өгүүллэгийн бүтцийн холбоо хамаарлаас гол санааг ойлгосноо харуулах	"5.1.б. Нэг сэдэвтэй хоёр эхийн утгыг харьцуулах замаар эхийн агуулгыг ойлгосноо харуулах 5.1.в.Уншсан жүжгийн гол санааг тайлбарлах"
	1.1.в. Уншсан эхийн үйл явдлыг асуултын дагуу тоочих (эхлээд? дараа нь, эцэст нь?)	2.1.в. Уншсан үлгэр, өгүүллэгийн үйл явдлыг дарааллын дагуу тоочих	3.1в. Уншсан үлгэр, өгүүллэг дэх баатрын үйл хөдлөлийн учир шалтгааныг тайлбарлах	4.1в. Уншсан эх, үлгэр, өгүүллэгийн бүтцийн хэсгүүдийн учир шалтгааныг тайлбарлах	5.1.г. Уншсан эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгүүдийн утгын холбоо хамаарлыг тайлбарлах
				4.1г Шүлэг дэх хоёр зүйлийн ижил төстэй шинжийг харьцуулан адилтган дүрслэлийг тайлбарлах	5.1.д. Эхээс хүншүүлсэн, хэтрүүлсэн дүрслэлийг тайлбарлах замаар үлгэрийн утгыг ойлгосноо харуулах
			3.1г. Эхээс баатрын болон зохиогчийн үгийг ялгах	4.1д. Эхэд ашигласан баримт ба өгүүлэгчийн үзэл бодлыг илэрхийлсэн хэсгийг ялгах	5.1.е. Үлгэрт амьдралын бодит байдлыг тусгасан эс тусгасан шинжээр нь бодит байдал ба уран сэтгэмжийг ялгах
	"1.1.г. Уншсан эхийн баатрын хийсэн зүйлийг тоочих "	2.1.г. Уншсан эхийн баатруудын сайн, муу үйлийг жишээгээр тайлбарлах	3.1д. Уншсан зохиолын баатруудын зан чанарыг эхээс жишээ татаж тайлбарлах	4.1е. Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсэгт баатруудын зан чанар, үзэл бодолд гар-сан өөрчлөлтийг харьцуулах	5.1.ж. Уншсан эхийн баатруудын харилцан ярианаас тэдний зан чанарыг дүгнэх
		2.1.д. Талархал, мэндчилгээ, товч анкет, гэр бүлийн танилцуулга, заавар зэргийг уншиж, агуулга, бүтцийг тайлбарлах	3.1е. Талархсан захидал, зорилгодоо хүрэх төлөвлөгөө, номын тэмдэглэл, хаяг, шошго зэргийг уншиж, агуулга, бүтцийг тайлбарлах	4.1ж. Уриалга, номын танилцуулга, сонины мэдээ, талархлын захидал зэргийн зорилго, бүтцийг тайлбарлах	5.1з. Захидлаас нэг сэдвийн талаар ялгаатай үзэл бодлыг харьцуулж дүгнэх
Бүтэцлээр ойлгож унших	1.1.д. Цээжилсэн хэл зүгш-рүүлэх үг, бэлгэ дэмбэрлийн үг, шүлгийг бусдын өмнө тод чанга дуугаар унших	2.1.е. Цээжилсэн шүлэг, зугаа үг, хэл зүгшрүүлэх үгийг бусдын өмнө тод чанга дуугаар унших	3.1ж. Цээжилсэн шүлгийн утгыг мэдэрч, мэдрэмжээ илэрхийлэн уран унших	4.1з. Хурд, дууны өнгөө тохируулан урнаар уншиж, шүлгийн утгыг ойлгосноо харуулах	"5.1и. Зохиолчийн санааг мэдэрч, уран унших
	1.1.е. Зохиолын баатруудын гадаад байдлыг төсөөлөх	2.1.ж. Өгсөн зургаас баатрууд хоорондоо юу ярилцсаныг ургуулан төсөөлөх	"3.1з. Үлгэр, өгүүллэгийн үйл явдлыг уншихдаа гол баатрын хэлэх үгийг ургуулан бодож, төсөөлөх"	"4.1и. Зохиолын баатрын гадаад дүр байдлыг ургуулан бодож төсөөлөх"	5.1к. . Үйл явдал хаана, хэзээ өрнөж байгааг ургуулан бодох төсөөлөх
		2.1.з. Өгсөн зургаас үндэслэн үйл явдлыг таамаглах	3.1и. Уншсан үлгэр, өгүүллэгийн гол хэсгийн үйл явдлыг хэрхэн өрнөхийг таамаглах	4.1к. Эхийн үйл явдлын төгсгөлийг үндэслэлтэйгээр таамаглах	5.1л. Онцгойн далд утгыг үндэслэлтэй таамаглах

Тайлбар: 3.1в, 3.1д суралцахуйн зорилтууд нь уншаад ойлгосноо тайлбарлах хүрээнд боловсруулагдсан ажлын хуудас ба өмнөх ангийн харгалзах суралцахуйн зорилтуудтай залгамж холбоотой.



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр.....цаг



- Аль нэг баатрын хийсэн үйлийг хөөж уншихад тэр ямар, ямар үйл хөдлөл хийсэн нь мэдэгдэнэ. Үүнээс шалтгааныг олж болно.
- Учир шалтгаан гэдэг нь яагаад тэр хэрэг явдлын үүсэх нөхцөл болоод шалтгаан, холбогдол нь юм.

1 Эхийг уншиж, ойлгоё.

Ах дүү хоёр модчин

Нэг ойд ах дүү хоёр модчин мод бэлтгэж байв. Ах модчин нь өглөө эртлэн босож ажилдаа гараад, хоол цай гэлгүй өдөржин ажиллаад, орой нар жаргасан хойно харьдаг байв.

Харин дүү модчин нь өглөө сайхан амарч босоод, хоол цайгаа идэж, ажилдаа гараад орой харанхуй болохоос өмнө гэртээ харьдаг байв.

Сарын дараа ах дүү хоёр модчин ажлаа дүгнэхэд дүү нь түрүүлсэн байв. Ах нь уурлаж би чамаас эрт босож ажилд гараад, шөнө хүртэл зогсолтгүй ажиллаж байхад яагаад чи түрүүлдэг билээ гэв.

Гэтэл дүү модчин инээмсэглэн "Та үүнд гайхаад байх хэрэггүй. Таныг зогсолтгүй ажиллаж байхад чинь би заримдаа амарч, амрах хугацаандаа сүхээ ирлэдэг байсан юм. Хурц сүхээр илүү бага хүч зарцуулан их ажил хийдэг юм" гэжээ.

2 Ах дүү хоёр модчины хийсэн үйл хөдлөлийг жагсаая.



Ах модчины хийсэн үйл

1. Өглөө эрт босдог.
2. Хоол цайгаа иддэггүй.
3. Өдөржин амралтгүй ажилладаг.
4. Нар жаргахаар харьдаг.
5. Түрүүлж чадаагүй.
6. Дүүдээ уурласан.



Дүү модчины хийсэн үйл

1.
2.
3.
4.
5.
6.



3 Баатруудын үйл хөдлөлийг шалтгаантай нь холбоорой.

Үйл хөдлөл нь

Ах нь өглөө эрт
босож, хоол цай
гэлгүй шөнө
болтол
ажилласан.

Дүү модчин
түрүүлсэн.

Ах нь дүүдээ
уурласан.

Ах модчин нь
хожигдсон.

Шалтгаан нь

Өглөөнөөс шөнө хүртэл
зогсолтгүй ажиллаж
байсан учраас

Хүч их
зарцуулсан ч сүхээ
ирлээгүй учир бага мод
бэлтгэсэн

Дүүгээсээ илүү сайн
ажиллаж түрүүлэхийг
хичээсэн учраас

Хүч бага
зарцуулсан ч сүхээ
ирлэсэн учир их мод
бэлтгэсэн

4 Эхээс сургамжтай байсан, чухал гэж үзсэн санаагаа бичээрэй.

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Баатруудын зан чанарыг эхээс жишээ татаж тайлбарлая



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр цаг

Хаанд бараалхсан нь

(Орос ардын үлгэр)

Нэг өвгөн эрдэнийн чулуу олоод хаандаа өргөхөөр шийджээ. Тэр хааны ордонд ирж: - Хаантай уулзаж болох уу? гэж асуужээ. Тэгэхэд хааны нэг хиа:- Юуны учир хаантай уулзах билээ гэж лавлахад өвгөн хэрэг учраа хэлжээ.

Хиа үүнийг сонсоод: - Сайн байна. Би хаанд айлтгая. Харин хааны хайрласан шангаас талыг нь надад заавал өгнө шүү. Үгүй гэвэл чамайг хаанд бараалхуулахгүй гэв. Өвгөн зөвшөөрч хаанд бараалхав. Хаан чулууг авснаа: - Танд ямар шан өгөх вэ? гэхэд өвгөн: - Намайг тавь ташуурдаж аль. Өөр шагнал хэрэггүй дээ. Таны хиа бид хоёр шангаа хувааж авахаар тохиролцсон юм. Тийм болохоор намайг хорин тав, тэр хиаг хорин тав ташуурдаж өгөөч гэв. Хаан учиргүй инээж, хиаг хөөн явуулж, өвгөнд мянган алтан зоос өгчээ.

Л.Толстой



хиа – хааны бараа бологч, үүдний сахиул

1

Дараах үгсээс тохирохыг сонгон авч, үлгэрт гарч буй баатруудын зан чанарыг тодорхойлоорой. Эхээс жишээ татан батлаарай.

Хэрэглэх үг: шуналгүй, шуналтай, авлигач, ухаантай, шударга, даруухан, сагсуу, шударга бус

баатрууд	зан чанар	Зан чанарыг эхээс жишээ татан нотолж тайлбарлаарай.
өвгөн	шударга	Учир нь өвгөн эрдэнийн чулуу олоод хаандаа өргөхөөр шийдсэн.
хаан		Учир нь
хиа		Учир нь

Дууссан:онсарөдөр цаг

Өөрийн үнэлгээ: (1) (2)